



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХИЙН СТАТИСТИК – 2013





ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХИЙН СТАТИСТИК – 2013

**УЛААНБААТАР
2014**

Санал, хүсэлт байвал доорхи хаягаар холбоо барина уу.

Үндэсний Статистикийн Хороо
Засгийн газрын III байр
Бага тойруу -44, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар -11, Монгол улс
Утас : (976-51)-261563; 262325
Факс : (976-11)-324518
Web хуудас : www.nso.mn, www.1212.mn
E-Mail : international@nso.mn; nso_hansg@nso.mn

Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргав.
Улаанбаатар хот, 2014

ГАРЧИГ

ГЭМТ ХЭРГИЙН ЕРӨНХИЙ ДҮР ЗУРАГ	1
1. УДИРТГАЛ	3
1.1 Гэмт хэргийн тухай ойлголт	3
1.2 Гэмт хэргийн мэдээллийн эх үүсвэр	4
2. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	5
2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн илрүүлэлт	6
2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр	9
2.3 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	23
2.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг хугацаа, газар	24
2.5 Гэмт хэрэг үйлдэгчид	26
3. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ	31
3.1 Гэмт хэргийн улмаас хохирсон байгууллага, иргэн	31
3.2 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт	36
4. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ	37
4.1 Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан	37
4.2 Шүүхээр ял шийтгүүлсэн хүн	38
4.3 Захиргааны зөрчил	40
5. ОЛОН УЛСЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС	42
6. ДҮГНЭЛТ	43
7. ЗӨВЛӨМЖ	46

ГЭМТ ХЭРГИЙН ЕРӨНХИЙ ДҮР ЗУРАГ

- Хүүхэд, гэр бүл, ёс суртахууны эсрэг 10 гэмт хэрэг тутмын 8 нь хүчингийн хэрэг байна.
- Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 6 нь нийслэлд гарсан байна.
 - 4 нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байна
- Халаасны хулгайн хэргийн 92.3 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.
- Нийслэлд бүртгэгдсэн халаасны хулгайн 10 хэрэг тутмын
 - 3 нь Сухбаатар дүүрэгт
 - 2 нь Баянгол дүүрэгт гарчээ.
- Гэмт хэргийн илрүүлэлт Завхан аймаг (41.1%), Баянзүрх дүүрэг (51.8%)-т хамгийн бага, Хөвсгөл аймаг (84.1%), Багануур дүүрэг (63.6%) хамгийн өндөр байна.
- Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 8 нь ажлын цагаар
 - 2 нь Даваа гаригт
 - 4 нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байна.
- Гудамж, талбайд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын 4 нь гэр хорооллын гудамжинд үйлдэгджээ.
- Хэрэгт холбогдсон 10 хүн тутмын
 - 5 нь ажилгүй байгаа
 - 5 нь 18-29 насны залуучууд
 - 4 нь бүрэн дунд боловсролтой
 - 2 нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.
- Гэмт хэргийн улмаас хохирсон 10 хүн тутмын
 - 5 нь 18-34 насны залуучууд
 - 6 нь эрэгтэйчүүд
 - 3 ажилгүй иргэд байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын
 - 8 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн
 - 6 нь тухайн хүчирхийлэгчдийн эхнэрүүд байна.
- 2013 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 8 эмэгтэй, 1 хүүхэд амь насаа алджээ.
- Гэмт хэргийн улмаас хохирсон 100 хүн тутмын 4 нь нас барж байгаа бол 10 хүн тутмын 4 нь гэмтэж байна.

	2012	2013	Өөрчлөлт
Хөнгөн гэмт хэрэг	9637	11648	↑
Хүндэвтэр гэмт хэрэг	10041	11514	↑
Хүнд хэрэг	1914	1766	↓
Онц хүнд хэрэг	497	434	↓
Хүнийг санаатай алах	231	204	↓
Малын хулгай	1376	1435	↑
Халаасны хулгай	249	426	↑
Танхайрах	1687	1839	↑
Хүчиндэх	305	344	↑
Согтуугаар үйлдэгдсэн хэрэг	5063	6406	↑
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг	534	418	↓
Гэмт хэргийн улмаас нас барсан	901	949	↑
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	8436	9797	↑
Гэмт хэргийн илрүүлэлт	56.3	58.5	↑

1. УДИРТГАЛ

1.1 ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг;
- Бусад гэмт хэрэг.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны суурин хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг **яллагдагч** гэнэ.

Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, ял шийтгэл эдэлж байгаа болон ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй этгээдийг **ял шийтгэгдсэн хүн** гэнэ.

Хүчингийн гэмт хэрэг гэж Монгол Улсын Эрүүгийн хуульд хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдэх гэмт хэргийг хэлнэ гэж тодорхойлсон байгаа.

Булаах гэмт хэрэг гэж бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж авсан ашиглан шамшигдуулах гэмт хэргийг хэлнэ.

Залилан мэхлэх гэмт хэрэг гэж бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг эзэмших эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан өмчлөх эрхийн эсрэг ашиглан шамшигдуулах гэмт хэргийг хэлнэ.

Танхайрах гэмт хэрэг гэж олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн гэмт үйлдлийг хэлнэ.

Албан тушаалын гэмт хэрэг гэж албан тушаалтнаас албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлддэг, төрийн аппаратын хэвийн үйл ажиллагаанд халдсан гэмт хэргийг хэлнэ.

1.2 Гэмт хэргийн статистикийн мэдээллийн үүсэл, эх үүсвэр

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодисын газар 1950 онд байгуулагдсанаар гэмт хэргийн статистик мэдээллийг олон улсын түвшинд цуглуулж эхэлсэн байна.

1933 онд батлагдсан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Цагдаагийн төв байгууллагын харьяанд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно, мөн хуулийн 28 дугаар зүйлд Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан байгуулж, ашиглана гэж заасан нь өнөөгийн Мэдээлэл, судалгааны төвийн эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн түүхтэй.

Манай улсад гэмт хэргийн мэдээлэл 1980-аад оноос улам өргөжин мэдээлэл технологийн дэвшилтэт арга технологийг ашиглах болж, улмаар гэмт хэргийн салбарын мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн байна.

Гэмт хэргийн мэдээллийг 1965 он хүртэл албан ёсоор нийтэд мэдээлдэггүй байсан нь гэмт хэргийн тухай бодит мэдээллийг олон түмнээс нууцалж байсантай холбоотой юм.

1993 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн 55 дугаар зүйлд “ Улсын Дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистик тоон мэдээлэл, практикийг нэгтгэн дүгнэж санал гаргах үүрэг бүхий шүүхийн судалгааны төв ажиллана” гэж заасны дагуу Шүүхийн судалгааны төв байгуулагдан ажилласнаар Монгол улсад шүүхийн статистикийн үндэс суурь тавигдсан түүхтэй.

Олон улсын түвшинд гэмт хэргийн статистик нь хоёр эх үүсвэрээс бүрддэг байна. Үүнд:

1. Гэмт хэрэг, шүүхийн албан ёсны мэдээлэл
2. Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн судалгаа

Манай орны хувьд гэмт хэргийн статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь одоогоор Цагдаагийн Ерөнхий Газрын сар бүрийн мэдээ, Улсын Дээд Шүүхийн хагас, бүтэн жилийн тайлан байна. Эдгээр мэдээллийн эх үүсвэрт үндэслэж гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, холбогдогч, хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, ял шийтгэгдсэн хүний тоо, шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргаан зэрэг үзүүлэлтийг сар, улирал, жилийн бюллетень, танилцуулга, эмхэтгэлд тусган нийтэд хүргэж байна.



2.ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Гэмт хэргийн гаралт, түүний хандлага, бүтэц, тархалт, гэмт хэрэг үйлдэгчдийн байдалд нөлөөлдөг үндсэн 3 хүчин зүйл байдаг:

- Эдийн засгийн хүчин зүйл
- Нийгмийн орчин
- Гэр бүлийн хүчин зүйл

Эдийн засгийн хүчин зүйлд санхүүгийн нөөцийн хомс байдал, ядуурал, боловсрол олж авах болон ажил эрхлэх боломж муу байх, орон сууцны нөхцөл муу байх, байгууллагын хариуцлага зэрэг олон зүйлүүд багтаж байдаг.

Нийгмийн орчны хүчин зүйлд гэр бүлд үзүүлэх дэмжлэг бага байх, хүүхэд, хувь хүний төлөвшилд анхаарал бага тавих, иргэдийн чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчин, нөхцөл муу зэрэг олон зүйлүүд багтдаг.

Гэр бүлийн хүчин зүйлд дараах зүйлүүд ордог. Үүнд:

- Эцэг, эхийн үл нийцэх байдал, хоорондын зөрчил
- Эцэг эх гэмт хэрэг үйлдэх, хэрэгт холбогдох
- Бие биеэ үл хүндэтгэх, хариуцлага хүлээхгүй байх
- Хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийлэх, хайхрахгүй байх
- Гэр бүлийн хүчирхийлэл


ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТАНД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД



2.1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ИЛРҮҮЛЭЛТ

Улсын хэмжээнд 2013 онд 25.4 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2000 оныхоос 1899 хэрэг буюу 8.1 хувь, 2005 оныхоос 7951 хэрэг буюу 45.7 хувь, 2007 оныхоос 4094 хэрэг буюу 19.2 хувь, 2012 оныхоос 3273 хэрэг буюу 14.8 хувиар нэмэгдсэн байна. (Зураг 2.1.1).

Зураг 2.1.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, 1990-2013 он



Бүртгэгдсэн гэмт хэрэг нэмэгдэхэд хэрэг бүртгэл сайжрах, хэрэг гарах үед сэжигтэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан хэрэг илрэх, гэмт хэргийн гаралт нэмэгдэх гэх зэрэг олон шалтгаантай байж болох юм. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хамгийн бага гэмт хэрэг бүртгэгдсэн жил 1990 он байсан бол хамгийн олон хэрэг бүртгэгдсэн жил нь 2013 он байна.

Зураг 2.1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сүүлийн 20 жилд



Улсын хэмжээнд 2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 14.9 хувь нь Төвийн бүсэд, 11.5 хувь нь Хангайн бүсэд, 6.1 хувь нь Баруун бүсэд, 5.9 хувь нь Зүүн бүсэд бүртгэгдсэн бөгөөд

нийт гэмт хэргийн 60.8 хувь нь нийслэлд, 38.4 хувь нь аймгуудад, 0.4 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.3 хувь нь иргэний агаарын тээврийн салбарт, 0.1 хувь нь бусад газарт бүртгэгджээ.


Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 45.4 хувийг хүндэвтэр, 45.9 хувийг хөнгөн, 7.0 хувийг хүнд, 1.7 хувийг онц хүнд хэрэг эзэлж, 2012 оныхоос хөнгөн хэргийн эзлэх хувь 2.3 пунктээр нэмэгдэж, онц хүнд хэргийнх 0.5 пункт, хүнд хэргийнх 1.7 пункт, хүндэвтэр хэргийнх 0.1 пунктээр буурав.

Хүснэгт 2.1.1. Бүртгээгдсэн гэмт хэрэг, ангиллаар, 2007-2013 он

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүртгэгдсэн гэмт хэрэг	21 268	20 704	20 373	19 825	19 197	22 089	25 362
Гэмт хэргийн ангиллаар							
Хөнгөн	7 881	7 854	7 857	8 151	7 977	9 637	11 648
Хүндэвтэр	9 786	10 165	10 006	9 219	8 889	10 041	11 514
Хүнд	3 158	2 352	2 126	2 014	1 823	1 914	1 766
Онц хүнд	443	333	384	441	508	497	434

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг 2012-2013 оны сараар авч үзэхэд, 2012 оны 1,3, 4,8, 9,10, 12-р сар, 2013 оны 1,4, 5, 7, 10, 12 - р саруудад өссөн дүнтэй, бусад саруудад буурсан байна. Эндээс үзэхэд жил бүрийн 1, 4, 10, 12-р саруудад гэмт хэрэг тогтмол нэмэгддэг байна. (Зураг 2.1.2).

Зураг 2.1.3. Гэмт хэргийн өсөлт, бууралт, 2012-2013 оноор, өмнөх сартай харьцуулсан хувиар



Гэмт хэргийн илрүүлэлт гэдэг нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргээс гэмт хэрэг үйлдсэн эзнийг нь тогтоож ял сонгосон хэргийн хувийн жингээр тооцогддог чанарын үзүүлэлт юм.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 43.0 хувийг бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг эзэлж байгаа нь 2012 оныхоос 6.2 пунктээр өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 2012 оныхоос улсын дүнгээр 2.2 пункт, нийслэлд 4.8 пунктээр нэмэгджээ (Хүснэгт 2.1.2).

Хүснэгт 2.1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэргийн илрүүлэлт, 2007-2013 он

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүртгэгдсэн гэмт хэрэг	21 268	20 704	20 373	19 825	19 197	22 089	25 362
Бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг	6 880	6 692	7 086	6 445	6 504	8 140	10 910
Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоосон хэрэг	1 956	2 231	3 890	3 859	3 999	4 585	6 382
Илрүүлэлтийн хувь	28.4	33.3	54.9	59.9	61.5	56.3	58.5

2013 оны байдлаар гэмт хэргийн илрүүлэлт хамгийн бага байгаа аймаг Завхан, хамгийн өндөр байгаа аймаг Хөвсгөл байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын дундажаар 58.5 хувь, нийслэлийн хувьд 56.5 хувь, аймгуудын хувьд 41.1-84.1 хувьтай байна.

Зураг 2.1.4 Гэмт хэргийн илрүүлэлт, хувиар, 2013 он



Гэмт хэргийн илрүүлэлт 2013 онд нийслэлд 2.2 пунктээр буурахад Баянгол, Хан-Уул, Багануур дүүргүүдэд гэмт хэргийн илрүүлэлт 2.2-3.6 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ. Бусад дүүргүүдэд гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн байна.

Зураг 2.1.5 Гэмт хэргийн илрүүлэлт, дүүргээр, хувиар, 2013он




2.2. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТӨРЛӨӨР

2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл, нийт гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 43.8 хувь, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 32.2 хувь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8.5 хувь, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7.5 хувь, бусад гэмт хэрэг 8.0 хувийг эзэлж байна.

Бүртгэгдсэн хэргийн дотор өмчлөх эрхийн эсрэг хэргүүд буюу бүх төрлийн хулгай, бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх, залилан мэхэлж авах, завших үрэгдүүлэх хэргүүдийн эзлэх хувийн жин 2013 онд өмнөх оныхоос 3.0 пунктээр нэмэгджээ.

Зураг 2.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он




Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2013 онд 8156 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 14.0 хувиар буюу 1001 тохиолдлоор нэмэгджээ. Энэ төрлийн гэмт хэрэг 2010 он хүртэл жил дараалан өсч байснаа 2011 онд буурч, сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.

Хүснэгт 2.2.1. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он

Хэргийн төрөл	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4 526	4 512	5 280	5 843	6 524	6 808	6 813	6 462	7 155	8 156
Үүнээс:										
- Хүнийг санаатай алах	335	310	311	300	213	223	230	262	231	204
- Бусдыг болгоомжгүй алах	19	16	15	14	23	16	15	21	14	21
- Бусдын биед гэмтэл учруулах	2 846	2 991	3 584	4 614	5 319	5 770	5 821	5 838	6 546	7 564
- Бусдыг амиа хорлоход хүргэх	1 293	1 167	1 340	888	945	764	727	314	324	323
- Амиа хорлосон хүн							119	51	46	48
- Золгүй явдлаас нас барсан							608	263	278	275
- Бусад	33	28	30	27	24	35	20	27	40	44
Дүнд харьцуулсан хувь										
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:										
- Хүнийг санаатай алах	7.4	6.9	5.9	5.1	3.3	3.3	3.4	4.1	3.2	2.5
- Бусдыг болгоомжгүй алах	0.4	0.4	0.3	0.2	0.4	0.2	0.2	0.3	0.2	0.3
- Бусдын биед гэмтэл учруулах	62.9	66.3	67.9	79.0	81.5	84.8	85.4	90.3	91.5	92.7
- Бусдыг амиа хорлоход хүргэх	28.6	25.9	25.4	15.2	14.5	11.2	10.7	4.9	4.5	3.9
Амиа хорлосон хүн							16.4	16.2	14.2	14.9
Золгүй явдлаас нас							83.6	83.8	85.8	85.1
- Бусад	0.7	0.6	0.6	0.5	0.4	0.5	0.3	0.4	0.6	0.6

Зураг 2.2.2. Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он


Бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн 13.2 хувийг бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг эзэлж байгаа нь 2012 оныхоос 2.3 пунктээр нэмэгдсэн байна. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлт 85.1 хувь байгаа нь 2012 оныхоос 10.5 пунктээр нэмэгджээ.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 92.7 хувийг бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 1.2 пунктээр нэмэгджээ. Бусдыг санаатай болон болгоомжгүй алах гэмт хэргийн энэ төрлийн хэрэгт эзлэх хувь буурчээ.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 57.3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Дархан-Уул (303), Төв (253), Сэлэнгэ (255), Баян-Өлгий(224), Орхон (218), Өвөрхангай (208), аймагт энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна.


Хүнийг санаатай алах гэмт хэрэг 2004-2008 онд тасралтгүй буурч, 2009-2011 онд нэмэгдэж, харин 2013 онд 204 болж, 31 хэрэг буюу 11.8 хувиар буурсан байна. Энэ төрлийн хэрэг сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Хүнийг санаатай алах хэргийн илрүүлэлт 92.6 хувь байна. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хүнийг санаатай алах гэмт хэрэг 1991 онд хамгийн бага, 2000 онд хамгийн олон бүртгэгдсэн байна.

Зураг 2.2.2. Хүнийг санаатай алах гэмт хэрэг, 1991-2013 он



Хүнийг санаатай алах хэрэг Хөвсгөл, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ, Төв Хэнтий аймагт буурсан хэдий ч Сүхбаатар, Ховд, Өвөрхангай, Увс, Баянхонгор, Дархан-Уул, Дундговь, Дорнод аймагт нэмэгдсэн байна. (Зураг 2.2.3)

Зураг 2.2.3. Хүнийг санаатай алах гэмт хэргийн гаралт өндөртэй аймаг, 2013 он



Зураг 2.2.4. Хүнийг санаатай алах гэмт хэрэг, сүүлийн 20 жилд



Хүнийг болгоомжгүй алах гэмт хэрэг 2013 онд 21 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 7-оор нэмэгджээ. Энэ хэргийн илрүүлэлт 100.0 хувь байна.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 92.7 хувийг бусдын биед гэмтэл учруулах хэрэг эзэлж байна. Энэ хэргийн илрүүлэлт 84.6 хувь болсон нь 2012 оныхоос 10.0 пунктээр нэмэгджээ.

Зураг 2.2.5. Хүний амь бие эрүүл сэндийн эсрэг гэмт хэрэг ба бусдын биед гэмтэл учруулах гэмт хэргийн харьцаа, 1990-2013 он



Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 57.3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Дархан-Уул (303), Төв (253), Сэлэнгэ (255), Баян-Өлгий(224), Орхон (218), Өвөрхангай (208), аймагт энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгийнхаас их байна. Амиа хорлосон 48 хүн, золгүй учралаар амь насаа алдсан 275 хүн байгаа нь өмнөх оныхоос амиа хорлосон хүн 4.3 хувиар өсч, золгүй учралаар амь насаа алдсан хүн 1.1 хувиар буурсан байна.

2013 онд амиа хорлосон хүмүүсийн 95.8 хувь нь өөрийгөө боомилсон, золгүй явдлаас амь насаа алдсан хүмүүсийн 16.4 хувь нь өвчний улмаас, 8.4 хувь нь архинд гүн хордсоны улмаас, 3.3 хувь нь осгож хөлдсөний улмаас нас барсан байна. 2013 оны эцсийн байдлаар, нийт 323 хүн амиа хорлосон болон золгүй байдлаар нас баржээ. Эдгээр хүмүүсийн 1.9 хувь нь хүүхдүүд, 3.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Амиа хорлосон болон золгүй байдлаар нас барсан хүмүүсийн 16.7 хувь нь согтуугаар нас барсан байна.

Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг

Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэгт хүнийг хууль бусаар хорих, доромжлох, гүтгэх, хүнийг барьцаалах, хүн худалдаалах гэмт хэргүүд ордог¹. Энэ төрлийн гэмт хэрэг 2013 онд 55 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 9 хэрэг буюу 19.6 хувиар өссөн байна. Энэ төрлийн хэргийн бүрэлдэхүүнд ордог хүн худалдаалах гэмт хэрэг 2009 онд 12, 2010 онд 1, 2011 онд 6, 2012 онд 9 байсан бол 2013 онд 10 болж өссөн байна.

Хүснэгт 2.2.2. Хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, 2005-2013 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд	352	343	384	426	375	410	434	405	425
Үүнээс:									
Хүчиндэх	320	314	355	354	332	342	367	305	344
Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах	-	-	-	27	10	10	15	14	13


Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2013 онд 425 болж, өмнөх оныхоос 20 хэрэг буюу 4.9 хувиар өссөн байна. Энэ төрлийн хэргийн 80.9

хувийг эзэлж байгаа хүчингийн хэрэг 2013 онд 344 бүртгэгдэж, өмнөх оныхоос 39 хэрэг буюу 12.8 хувь, хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг 14 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 1 хэрэг буюу 7.7 хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.2.6).

Хүчингийн хэргийн гаралт 2012 оныхоос 39 хэрэг буюу 12.8 хувиар өссөн байна (Зураг 2.2.6). Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2012 онд 14 байсан бол 2013 онд 13 болж буурчээ.

Зураг 2.2.6. Хүчингийн гэмт хэрэг, 1990-2013 он



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг


Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2013 онд 11118 бүртгэгдэж, өмнөх оныхоос 2095 хэрэг буюу 23.2 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 70.9 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 1618-аар, халаасны хулгайн хэрэг 177-оор, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж, авах хэрэг 133-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд ордог дийлэнх төрлийн гэмт хэрэг сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай хэдий ч авто тээврийн хэрэгсэл хулгайлах хэрэг 21.5 хувиар буурсан байна. (Хүснэгт 2.2.2.)

Зураг 2.2.2. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2004-2013 он

Хэргийн төрөл	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд	10 138	8 896	8 847	10 865	9 489	8 853	7 944	7 232	9 023	11 118
Үүнээс:										
Хулгай	7 861	6 683	6 657	7 927	6 609	6 376	5 777	5 276	6 266	7 884
Булаалт	328	327	418	703	354	167	143	137	179	227
Дээрэм	655	584	455	656	818	754	520	536	552	620
Залилан	697	678	669	816	866	801	764	688	1 098	1231
Завших, үрэгдүүлэх	338	371	341	357	331	347	337	202	269	326


Хулгайн гэмт хэргийн тоо 2013 онд 7884 бүртгэгдэж, 2012 оныхоос 1618 хэрэг буюу 25.8 хувь, булаах гэмт хэрэг 48 хэрэг буюу 26.8 хувь, дээрэм 68 хэрэг буюу 12.3 хувь, залилан 133 хэрэг буюу 12.1 хувиар өссөн байна.

Зураг 2.2.7. Хулгайн хэргийн бүтэц, төрлөөр, 2012-2013 он



Иргэдийн өмчийг хулгайлах хэрэг 1991 оноос 2000 он хүртэлх хугацаанд өссөн бөгөөд 2004 оноос хойш буурч байгаад сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.


Зураг 2.2.8. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг, 1990-2013 он



Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 1990 оноос 1993 онд эрс нэмэгдэж 9242-д хүрсэн нь сүүлийн 23 жилийн хугацаанд хамгийн их хулгай гарсан жил байжээ. Энэ төрлийн гэмт хэрэг 1993-1999 оны хооронд тасралтгүй өсч байгаад 2000 оноос 2002 оны хооронд буурч, харин сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна.


Малын хулгайн гэмт хэрэг 2013 онд 1435 болж, өмнөх оныхоос 59 хэрэг буюу 4.3 хувиар өссөн байна.

Зураг 2.2.9. Малын хулгайн гэмт хэрэг, 2005-2013 он




2013 онд малын хулгай Төв(208), Дорнод(170), Хэнтий(121), Архангай(99), Булган(92), Хөвсгөл(83) аймгуудад хамгийн их гарсан бол Өмнөговь(8), Говь-Алтай(6), аймгуудад хамгийн бага малын хулгай бүртгэгдсэн байна.

Зураг 2.2.10. Малын хулгайн гаралт ихтэй аймгууд, 2013 он



Тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг 135 болж, өмнөх оныхоос 37 хэрэг буюу 21.5 хувиар буурав.

Зураг 2.2.11. Тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг, 2005-2013 он



Хувийн өмч хулгайлах гэмт хэргийн 7.3 хувийг эзэлдэг халаасны хулгай тууштай буурахгүй байгаа бөгөөд 2013 онд энэ төрлийн 426 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оныхоос 177 хэрэг буюу 71.1 хувиар өссөн байна. Халаасны хулгайн 92.3 хувь нь нийслэлд бүртгэгдсэн бөгөөд Сүхбаатар дүүрэгт 129 хэрэг буюу 32.8 хувь, Баянгол дүүрэгт 101 тохиолдол буюу 25.7 хувь нь бүртгэгджээ.

Булаах гэмт хэрэг 2013 онд 227 бүртгэгдэж, өмнөх оныхоос 48 хэрэг буюу 26.8 хувь, завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 326 болж, өмнөх оныхоос 57 хэрэг буюу 21.2 хувь, залилан мэхлэх хэрэг 1231 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 133 хэрэг буюу 12.1 хувиар нэмэгдэв.


Зураг 2.2.12. Бусдын эд хөрөнгийг булаах, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх гэмт хэргийн гаралт, 2003-2013 он



Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 2013 онд 620 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 68 хэрэг буюу 12.3 хувиар нэмэгдсэн байна.

Дээрмийн хэрэг 2003 онд 825 бүртгэгдэж байсан нь 1991 оноос хойшхи 22 жилийн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлт юм.


Зураг 2.2.13. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэг, 1991-2013 он




Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2013 онд 1894 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 145 хэрэг буюу 8.3 хувиар нэмэгджээ. 2013 онд бүртгэгдсэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 40.1 хувь нь бүртгэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй, 31.0 хувь нь ял сонгосон хэрэг байгаа ба энэ төрлийн хэргийн илрүүлэлт 77.4 хувьтай байна.

Зураг 2.2.14. Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2003-2013 он




Зураг 2.2.15. Танхайрах гэмт хэрэг, 1990-2013 он

Танхайн гэмт хэрэг 2013 онд 1839 бүртгэгдсэн ба 2012 оныхоос 152 хэрэг буюу 9.0 хувиар нэмэгдэхэд энэ төрлийн гэмт хэргийн тоо Говь-Алтай аймагт 14 хэрэг буюу 2.3 дахин, Дархан-Уул аймагт 21 хэрэг буюу 75.0 хувь, Төв аймагт 10 хэрэг буюу 45.5 хувь, Булган аймагт 7 хэрэг буюу 2 дахин, Өмнөговь аймагт 9 хэрэг буюу 81.8 хувь, Улаанбаатар хотод 203 буюу 16.3 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.


Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам (ТХХАБАЖ)-ын эсрэг гэмт хэрэг 2013 онд 2148 болж, өмнөх оныхоос 149 хэрэг буюу 7.5 хувиар өссөн байна.

Зураг 2.2.16. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 1990-2013 он


Энэ төрлийн гэмт хэргийн 56.4 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 66.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг (ТХХАББАЖЗ), 31.7 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэрэг эзэлж байна.

Зураг 2.2.17. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн бүтэц, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он



Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн дотор голлох хувийг эзэлж байгаа ТХХАББАЖЗ гэмт хэрэг 2012 оныхоос 4.2 пункт, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргүүд 4.0 пунктээр нэмэгдсэн байна. Зам тээврийн ослын үед үүргээ биелүүлэхгүй байх, зугтах хэрэг 2009 оноос хойш тасралтгүй өссөн хэдий ч 2013 онд 4.5 хувиар буурчээ. Харин тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2012 оныхоос 181 хэргээр өссөн байна.

Зураг 2.2.18. ТХХАББАЖЗ гэмт хэрэг, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн гаралт, 2005-2013 он



Хүснэгт 2.2.3. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, 2007-2013 он


	2007	2008	2009	2010	2011	2012	2013
ТХХАББАЖЗ гэмт хэрэг	1096	977	998	1116	1261	1238	1419
Нас барсан хүний тоо	1597	1551	1358	1191	922	901	949
Үүнээс: Зам тээврийн ослын улмаас	344	313	317	325	363	369	424

Гэмт хэргийн улмаас 2013 онд 949 хүн нас барсны 424 хүн буюу 44.7 хувь нь зам тээврийн ослын улмаас нас баржээ.

Албан тушаалын гэмт хэрэг


Албан тушаалын гэмт хэрэг 2013 онд 106 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 4 хэрэг буюу 3.6 хувиар буурсан байна. 1990 оноос хойшхи 23 жилийн хугацаанд 2001 онд албан тушаалын гэмт хэргийн гаралт хамгийн олон бүртгэгджээ.

Зураг 2.2.19. Албан тушаалын гэмт хэргийн гаралт, 1990-2013 он




Хээл хахууль авах 12 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2012 оныхоос 4 хэрэг буюу 25.0 хувиар буурч, харин хээл хахууль өгөх гэмт хэрэг өмнөх оны түвшинд, хээл хахуульд зуучлах гэмт хэрэг 1 шинээр бүртгэгджээ.

Зураг 2.2.20. Хээл хахуулийн гэмт хэргийн тоо, 2006-2013 он



Улсын дунджаар 18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд 2013 онд 133 гэмт хэрэг ногдож байгаа нь 1990 оныхоос 2.1 дахин, 2006 оныхоос 21 хэрэг буюу 18.8 хувь, 2012 оныхоос 16 хэрэг буюу 13.7 хувиар өссөн байна.

Зураг 2.2.21. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг, 1990-2013 он




Сүүлийн 23 жилд 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ноогдох гэмт хэрэг 1997 онд хамгийн их (193) байна. 2013 онд улсын дунджаар 18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд 133 гэмт хэрэг ногдож байгаа бөгөөд Говьсүмбэр (180), Дорноговь (138), Дорнод (148), Төв (155) аймаг, Улаанбаатар (182) хотод улсын дунджаас дээгүүр байна.

2.3. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БАЙДАЛ

2013 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 6406 буюу 25.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг байгаа бөгөөд 2006 оныхоос 2703 хэрэг буюу 73.0 хувь, 2012 оныхоос 1343 хэрэг буюу 26.5 хувиар өсөв.

Зураг 2.3.1. Гэмт хэрэг үйлдсэн байдал, 2006-2013 он



Бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 2013 онд 2447 болж, өмнөх оныхоос 20 хэрэг буюу 0.8 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 3160 болж, өмнөх оныхоос 399 хэрэг буюу 14.25 хувиар нэмэгдэж, хүүхэд оролцсон хэрэг 1029 болж, 47 хэрэг буюу 4.4 хувиар буурсан байна. (Зураг 2.3.1).

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэгдэх явдал нилээд байгаа бөгөөд 2013 онд энэ төрлийн гэмт хэрэг 418 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 116 хэрэг буюу 21.7 хувиар буурсан байна.

Зураг 2.3.2. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, 2008-2013 он




2.4. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАРАГ, ЦАГ ХУГАЦАА, ГАЗАР

2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 75.7 хувь нь ажлын өдөр, 24.3 хувь нь амралтын өдөр үйлдэгджээ. Нийт гэмт хэргийн 16.0 хувь нь даваа гарагт үйлдэгдсэн бөгөөд үүний 61.5 хувь нь нийслэлд, 38.5 хувь нь аймгуудад байна. Ажлын өдөрт үйлдэгдсэн нийт хэргийн 21.2 хувь нь Даваа гарагт үйлдэгдсэн байна.


Зураг 2.4.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн гарагаар, дүнд эзлэх хувиар 2013 он



2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байгаа бөгөөд энэ дүр зураг нийслэл, аймагт ижил байна. Улсын хэмжээгээр бүртгэгдсэн гэмт хэргийн 17.9 хувь нь 06-14 цагт, 25.2 хувь нь 14-19 цагт, 17.9 хувь нь 19-22 цагт, 39.0 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.

Зураг 2.4.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн цагаар, 2013 он

2013 онд Улаанбаатар хотод бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 36.7 хувь нь шөнийн 22 цагаас өглөөний 06 цагийн хооронд, 25.4 хувь нь 14-19 цагийн хооронд, 19.6 хувь нь 06-14 цагийн хооронд, 18.3 хувь нь 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 28.2 хувь нь гэр, орон сууцанд, 21.1 хувь нь гудамж, талбайд үйлдэгджээ.

Зураг 2.4.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2013 он

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэргийн 40.7 хувь нь гэрт, 20.5 хувь нь орон сууцны байранд, 25.6 хувь нь хувийн байшин, зуслангийн байшин, амины орон сууцанд, 7.7 хувь нь гарааж, амбаар, агуулах, орц, подвальд, 5.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна. Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн 41.6 хувь нь гэр хорооллын гудамжинд, 28.5 хувь нь орон сууцны хорооллын гудамжинд үйлдэгджээ.

Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэргийн 19.7 хувь нь дэлгүүрт, 22.4 хувь нь бааранд, 10.5 хувь нь худалдаа үйлчилгээний захад, 10.1 хувь нь зочид буудалд үйлдэгдсэн байна.

Авто зам дээр гарсан гэмт хэргийн 61.0 хувь нь хотын замд, 34.6 хувь нь орон нутгийн замд гарсан ба замын хучилтаар авч үзвэл, 71.2 хувь нь асфальтан зам дээр, замын гадаргуугийн хувьд 60.5 хувь нь хуурай гадаргууд, замын онцлогоор харвал 60.2 хувь нь тэгш, 51.6 хувь нь шулуун замд үйлдэгджээ.


Бусад газарт үйлдэгдсэн гэмт хэргийн 44.3 хувь нь хөдөө хээр, бэлчээрт үйлдэгдсэн байна.

2.5 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧИД

Хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу хэрэг үүсгэж сэжигтнээр татагдсан этгээдийг сэжигтэн, харин хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж яллагдагчаар татагдсан этгээдийг яллагдагч гэнэ.


Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчдын тоо 2013 онд 22.3 мянган хүн болж, 2000 оныхоос 1934 хүн буюу 9.5 хувь, 2006 оныхоос 5461 хүн буюу 32.5 хувь, 2012 оныхоос 2552 хүн буюу 12.9 хувиар өссөн байна. (Зураг 2.4.1).

Зураг 2.5.1. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид, 2005-2013 он



Нийт 22.3 мянган хүн 2013 онд сэжигтэн, яллагдагчаар татагдсаны 3137 буюу 14.1 хувь нь эмэгтэйчүүд, 1222 буюу 5.5 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.


Зураг 2.5.2. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч эмэгтэйчүүд, хүүхэд 2003-2013 он



Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчдын 46.4 хувийг 18-29 насны залуучууд, 27.5 хувийг 30-39 насныхан эзэлж байна. Хэрэгт холбогдсон нийт хүмүүсийн 1.5 хувь нь 15 хүртэлх насных, 4.0 хувь нь 16-17 насны хүүхдүүд, 20.6 хувь нь 40-с дээш насныхан байна.

Зураг 2.5.3. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид, насны бүлгээр, 2013 он


2013 он



Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 50.7 хувь нь ажилгүй иргэд, 7.1 хувь нь оюутан, сурагчид, 32.1 хувь нь ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүс байна.


Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад ажилгүй иргэдийн эзлэх хувь 50.7 болж өмнөх оны мөн үеийнхээс 2.0 пункт, хувийн байгууллагад ажиллагчдынх 9.5 хувь болж 1.6 пункт, малчдынх 9.0 хувь болж 0.5 пункт, сурагчдынх 2.6 хувь болж 0.2 пунктээр буурч, харин хувиар хөдөлмөр эрхлэгчдийнх 15.7 хувь болж 3.6 пункт, төрийн бус байгууллагынх 2.4 хувь болж 0.5 пункт, төрийн албан хаагчийнх 4.4 хувь болж 0.1 пункт, сургууль завсардсан хүүхдийнх 4.5 болж 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 2.5.4. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын тоо, нийгмийн байдлаар, 2013 он




Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчдыг боловсролын түвшингээр авч үзвэл 42.0 хувийг бүрэн дунд боловсролтой, 23.8 хувийг суурь боловсролтой, 17.1 хувийг дээд боловсролтой, 9.9 хувийг бага боловсролтой хүмүүс эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос бүрэн дунд боловсролтой сэжигтэн, яллагдагчдын эзлэх хувь 0.6 пункт, бага боловсролтойнх 0.6 пункт, суурь боловсролтойнх 0.1 пунктээр буурч, суурь боловсролтойнх 0.5 пункт, дээд боловсролтойнх 0.3 пункт, боловсролгүйнх 0.2 пункт, тусгай мэргэжлийн боловсролтойнх 0.3 пунктээр өссөн байна.

Зураг 2.5.5. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид, боловсролын түвшингээр, 2012-2013 он



Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчдын 25.6 хувь нь согтуу байхдаа гэмт хэрэг үйлдсэн бол 18.4 хувь нь бусадтай бүлэглэн гэмт хэрэг үйлджээ. Нийт сэжигтэн, яллагдагчдын 4.6 хувь нь өмнөх ял шийтгэлийн хугацаа нь дуусаагүй хүмүүс байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 28.7 хувь нь согтуугаар, 11.0 хувь нь бүлэглэж, 0.3 хувь нь урьдчилан үгсэн тохиролцож гэмт хэрэг үйлдсэн бол 60.0 хувь нь тодорхой шалтгаангүйгээр гэмт хэрэг үйлджээ.

Зураг 2.5.6. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг ба согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, 2008-2013 он



Зургаас харахад сүүлийн 6 жилийн хугацаанд дотооддоо үйлдвэрлэсэн согтууруулах ундааны хэмжээ буурах хандлагатай байгаа боловч импортоор оруулж ирсэн согтууруулах ундааны хэмжээ 2009 оноос хойш тасралтгүй нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг тууштай буурахгүй байгаа бөгөөд гэмт хэрэгт холбогдсон 10 сэжигтэн, яллагдагч тутмын 3 нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.

3.1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

3.1 Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, байгууллага


Гэмт хэргийн улмаас 2013 онд нийт 25015 иргэн, 157 байгууллага хохирсон нь 2012 оныхоос хохирогч иргэдийн тоо 3721 хүнээр нэмэгдэж, харин хохирогч байгууллагын тоо 10-аар буурчээ. Гэмт хэргийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоо 9838 болж, өмнөх оныхоос 1861 хүнээр өссөн байна. Хохирогчдын 60.7 хувь буюу 15177 нь эрэгтэйчүүд байна.

Хүснэгт 3.1.1. Хохирогч иргэд, байгууллага, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2013 он

Онууд	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	Хохирогч иргэдийн тоо			Хохирогч байгууллагын тоо			Учирсан хохирол.тэрбум төг			Нөхөн төлүүлэлт тэрбум төг	Гэмт халдлагат өртсөн гадаадын иргэд
		Нийт	Эмэгтэй	хүүхэд	Нийт	төрийн	хувийн	Бүгд	төрийн	хувийн		
2007	21 268	19 931	6 115	1 151	975	456	446	29.5	10.9	15.8	4.0	199
2008	20 704	20 256	6 175	1 080	1044	490	396	54.8	10.9	22.7	7.0	211
2009	20 373	19 545	6 312	1 045	824	468	307	49.2	13.6	25.8	18.0	149
2010	19 825	19 381	7 097	1 066	358	234	74	33.4	8.8	24.4	14.3	133
2011	19 197	18 592	6 856	1 178	184	128	42	35.9	10.0	25.4	18.5	111
2012	22 089	21 294	7 977	1 270	167	88	55	53.3	9.6	42.8	25.1	121
2013	25 362	25 015	9 838	1 426	157	99	48	159.0	79.0	72.9	111.3	126

Хохирогчдын 49.2 хувийг 18-34 насны залуучууд эзэлж байна. 18 хүртэлх насны хохирогчдын 13.0 хувь нь 7 хүртэлх насны, 27.7 хувь нь 8-13 насны, 59.3 хувь нь 14-17 насны хүүхдүүд байна.

Зураг 3.1.1. Гэмт хэргийн улмаас нийт хохирсон иргэд, насны бүлгээр, 2013 он




Хохирогчдын 31.8 хувийг нь ажилгүй иргэд эзэлж байгаа нь 2012 оныхоос 622 хүн буюу 2.7 пунктээр буурчээ. Хохирогч иргэдийн 8.7 хувь нь оюутан, сурагчид, 8.3

хувь нь төрийн албан хаагчид байна. Нийт хохирсон төрийн албан хаагчдын 134 буюу 6.4 хувь нь цагдаагийн албан хаагчид байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон гадаад улсын иргэдийн тоо 2013 оны эцэст 126 болж, өмнөх оныхоос 5 хүнээр нэмэгдсэн ба гэмт халдлагад өртсөн гадаадын иргэдийн 38.9 хувь нь БНХАУ-ын иргэд байна.


Зураг 3.1.2. Гэмт халдлагад өртсөн гадаадын иргэд, улсаар, 2011-2013 он



Хохирогч өөрийн буруугаас болж хохирсон тохиолдол 365 гарсан нь 2012 оныхоос 238 буюу 39.5 хувиар буурчээ. Архидан согтуурсны улмаас 371 хүн хохирсон нь өмнөх оныхоос 70 хүн буюу 15.9 хувиар буурчээ.

2013 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 319 хүн хохирсон нь 2012 оныхоос 114 хүн буюу 26.3 хувиар буурав. Эдгээр хүмүүсийн 84.0 хувь нь бие махбодын хүчирхийлэлд өртжээ. Хохирогчдын 63.9 хувь нь 1 жил хүртэл, 14.7 хувь нь 1-3 жилийн туршид хүчирхийлэлд автаж байсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлд автсан хүмүүсийн 63.0 хувь нь жилд 1-2 удаа, 2.2 хувь нь байнга хүчирхийлэлд автагджээ. Гэр бүлийн хүчирхийллээс хохирсон хүмүүсийн 64.3 хувийг эхнэр нь, 11.6 хувийг хамтран амьдрагч нь, 1.0 хувийг төрсөн хүүхэд нь, 2.2 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас нийт 167 байгууллага хохирсон нь 2012 оныхоос 10 байгууллага буюу 6.0 хувиар буурчээ. Эдгээр байгууллагын 63.1 хувь нь төрийн байгууллага байгаа бөгөөд өмнөх оноос 11-ээр нэмэгджээ. 2013 онд хувийн өмчийн 48 байгууллага хохирсон нь 2012 оныхоос 12.7 хувиар буурсан байна.


Зураг 3.1.3. Гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн иргэд, 2007-2013 он

Гэмт хэргийн улмаас 2013 онд 25015 хүн хохирсны 3.8 хувь буюу 949 хүн нас барж, 39.2 хувь буюу 9797 хүн гэмтсэн байна. Тайлант онд хохирогч иргэдийн тоо 17.5 хувиар нэмэгдэхэд нас барсан иргэдийн тоо 5.3 хувь, гэмтсэн иргэдийн тоо 16.1 хувиар нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас 2013 онд 949 хүн нас барсны 160 буюу 16.9 хувь нь хүнийг санаатай алсан, 424 буюу 44.7 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмыг зөрчсөний улмаас амь насаа алджээ. Гэмт хэргийн улмаас 74 хүүхэд нас барж, 721 хүүхэд гэмтсэн байна. Авто ослын улмаас 36 хүүхэд нас барж, 197 гэмтсэн байна.

Нас барсан хүмүүсийн 74.8 хувь нь эрэгтэйчүүд, 25.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд нас барагчдын 91.3 хувь нь 24 цагийн дотор, 7.7 хувь нь 30 хоногийн дотор, 1.1 хувь нь 30-аас дээш хоногт эмнэлгийн тусламж авсан байна.

Гэмт хэргийн улмаас нас барагчдын 48.5 хувийг 30-49 насны хүмүүс эзэлж байна.


Зураг 3.1.4. Гэмт хэргийн улмаас нас барсан хүн, хэргийн төрлөөр, 2012-2013 он

Гэмт хэргийн улмаас 2013 онд нас барсан 949 хүний 44.7 хувь нь ТХХАБАЖ-ийн эсрэг, 16.9 хувь нь хүнийг санаатай алах, 26.7 хувь нь бусдыг амиа хорлоход хүргэх, 1.9 хувь нь бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн улмаас нас баржээ. 2013 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 8 эмэгтэй, 1 хүүхэд амь насаа алджээ.

Хүснэгт 2.4.2. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, 2007-2013 он

	2007	2008	2009	2010	2011	2012	2013
ТХХАБАЖЗ гэмт хэрэг	1096	977	998	1116	1261	1238	1419
Нас барсан хүний тоо	1597	1551	1358	1191	922	901	949
Үүнээс: Зам тээврийн ослын улмаас	344	313	317	325	363	369	424


Зураг 3.1.5. Гэмт хэргийн улмаас нас барсан хүн, насны бүлгээр, 2012-2013 он



Гэмт хэргийн улмаас 2013 онд 9797 хүн гэмтэж, 2000 оныхоос гэмтсэн хүний тоо 1830 хүн буюу 22.9 хувь, 2006 оныхоос 3900 хүн буюу 46.7 хувь, 2012 оныхоос 1361 хүн буюу 16.1 хувиар нэмэгдэв. Гэмтсэн хүмүүсийн 63.4 хувь нь эрэгтэйчүүд, 36.6 хувь нь эмэгтэйчүүд байна.


Нийт гэмтсэн хүмүүсийн 6288 буюу 64.2 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас, 105 буюу 1.1 хувь нь хүчингийн хэргийн улмаас, 1459 буюу 14.9 хувь нь танхайрах гэмт хэргийн улмаас, 1282 хүн буюу 13.1 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна.

Зураг 3.1.6. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн, 2000, 2005-2013 он




2013 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн хүмүүсийн 77.3 хувь нь хөнгөн, 14.8 хувь нь хүндэвтэр, 7.9 хувь нь хүнд гэмтсэн байна.

Зураг 3.1.7. Гэмтсэн хүн, гэмтлийн зэргээр, дүнд эзлэх хувиар, 2012-2013 оноор



Гэмтсэн хүмүүсийн 54.9 хувийг 18-34 насны залуучууд, 7.4 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. 18 хүртэлх насны хүүхдүүдийн 58.9 хувь нь 14-17 насны хүүхдүүд байна.


Зураг 3.1.8. Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн, насны бүлгээр, 2013 он

3.2 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт


Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирол 2013 онд 159.0 тэрбум төг болж, 2000 оныхоос 135.7 тэрбум төг буюу 6.8 дахин, 2006 оныхоос 106.9 тэрбум төг буюу 3.1 хувь, 2012 оныхоос 105.7 тэрбум төг буюу 3 дахин нэмэгдэв.

Нөхөн төлүүлсэн хохирлын нийт хэмжээ 2013 онд 111.3 тэрбум төг болж, 2000 оныхоос 107.7 тэрбум төг буюу 30.9 дахин, 2006 оныхоос 105.4 тэрбум төг буюу 18.9 дахин, 2012 оныхоос 86.2 тэрбум төг буюу 4.4 дахин нэмэгдсэн байна. (Зураг 3.2.1).

Зураг 3.2.1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төг, 2000, 2005-2013 он



Зураг 3.2.2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2012-2013 он




4.1 .ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

4.1.1. Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиар 2013 онд 1080 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсэний 725 буюу 67.1 хувь нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 206 буюу 19.1 хувь нь цалин хөлсний маргаан, 36 буюу 3.3 хувь нь ажлаас буруу шилжүүлсэн хэрэг байна.

Зураг 4.1.1. Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан, шалтгаанаар, 2010-2013 он



Шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргааны 17.1 хувь нь баруун бүсэд, 14.0 хувь нь хангайн бүсэд, 12.6 хувь нь төвийн бүсэд, 5.8 хувь нь зүүн бүсэд, 50.5 хувь нь Улаанбаатар хотод байна. Хөдөлмөрийн маргаан 2010 оноос 102 буюу 10.4 хувь, 2011 оноос 183 буюу 20.4 хувь, 2012 оноос 338 буюу 45.6 хувиар нэмэгдэхэд ажлаас үндэслэлгүй халсан шалтгаан 266 буюу 58.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын “Дампуурлын тухай” хуулиар 2013 онд 11 аж ахуйн нэгж шүүхийн шийдвэрээр дампуурсан бөгөөд эдгээрийн 7 буюу 63.6 хувийнх нь хариуцагчийг татан буулгажээ.

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2013 онд 15571 хэрэг шийдвэрлэгдсний 3382 буюу 21.7 хувь нь гэр бүл цуцалсан, 313 буюу 2.0 хувь нь эцэг тогтоосон, 454 буюу 2.9 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг байна.


4.2.1. Шүүхээр ял шийтгүүлсэн хүн

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2013 онд 8065 болж, эдгээрийн 692 буюу 8.6 хувь нь эмэгтэйчүүд, 565 буюу 7.0 хувь нь хүүхдүүд, хүүхдүүдийн 18 буюу 3.2 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Ял шийтгүүлсэн хүмүүс тухайн жилд сэжигтэн, яллагдагчаар татагдсан хүмүүсийн 36.2 хувийг эзэлж байна.


Ял шийтгүүлэгчдийн 1698 буюу 21.1 хувь нь урьд ял шийтгүүлж байсан, 1028 буюу 12.7 хувь нь 2 дахь удаагаа ял шийтгүүлсэн, 689 буюу 8.5 хувь нь 3 ба түүнээс дээш удаа ял шийтгүүлсэн байна.

Зураг 4.2.1. Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, эмэгтэйчүүд, 18 хүртэлх насны хүүхэд,

2005-2013 он




2013 онд шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 48.8 хувийг 18-29 насны залуучууд, 18.1 хувийг 30-34 насныхан, 18 хүртэлх насны хүүхдүүдийн 63.5 хувийг 16-17 насныхан эзэлж байна.

Зураг 4.2.2. Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, насны бүлгээр, 2012-2013 он

2013

онд шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 50.4 хувь нь бүрэн дунд, 13.7 хувь нь суурь, 12.6 хувь нь бага боловсролтой хүмүүс байна.

Зураг 4.2.3. Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, боловсролын түвшингээр, хувиар, 2012-2013 он

Шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 8 буюу 0.1 хувь нь улс төрийн албан тушаалтан, 46 буюу 0.6 төрийн захиргааны албан хаагч, 51 буюу 0.6 хувь нь төрийн тусгай албан хаагч, 113 буюу 1.4 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 678 буюу 8.4 хувь нь оюутан, сурагчид, 4935 буюу 61.2 хувь нь ажил эрхлээгүй хүмүүс байна.

Ял шийтгүүлсэн хүмүүсийн 8017 буюу 99.4 хувь нь Монгол улсын иргэд, 48 буюу 0.6 хувь нь гадаадын харьяатууд байна.

Баривчлах ялаар 2013 онд 1034 хүн шийтгүүлсний 37 буюу 3.5 хувь нь эмэгтэйчүүд, 9 буюу 0.9 хувь нь хүүхдүүд байна. Ял шийтгүүлсэн 8065 хүний 6457 буюу 76.2 хувь нь хорих ялаар, 1034 буюу 12.8 хувь нь баривчлах ялаар, 272 буюу 3.7 хувь нь торгуулийн ялаар шийтгүүлсэн байна.

Анхан шатны шүүхийн захиргааны хэргийн мэдээгээр 2013 онд 1097 маргаан шийдвэрлэгдсний 280 буюу 25.5 хувь нь газрын маргаан, 203 буюу 18.5 хувь нь төрийн албаны маргаан, 103 буюу 9.4 хувь нь сонгуулийн маргаан, 72 буюу 6.6 хувь нь ашигт малтмалын маргаан, 65 буюу 5.9 хувь нь татварын маргаан, 34 буюу 3.1 хувь нь тендерийн маргаан, 16 буюу 1.5 хувь нь өмчийн маргаан, 46 хувь нь төрийн хяналт, шалгалттай холбоотой маргаан, 88 буюу 8.0 хувь нь үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлтэй хобоотой маргаан байна. Мөн анхан шатны шүүхийн эрүүгийн хэргийн мэдээгээр 2013 онд 295 хүнд 1.5 тэрбум төгрөгийн торгууль ноогдуулсан ба 75 буюу 25.4 хувь нь эмэгтэйчүүд, 2 буюу 0.7 хувь нь хүүхэд байна.


4.3 ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

Захиргааны зөрчил гэдэг нь бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Улсын хэмжээнд 2013 онд 777.8 мянган захиргааны зөрчил бүртгэгдсэн нь 2012 оныхоос 18.1 мянга буюу 2.3 хувиар буурсан байна.

2013 онд 123.5 мянган хүн эрүүлжүүлэгдсэн нь 2000 оныхоос 24.6 мянга буюу 16.6 хувь, 2006 оныхоос 12.6 мянга буюу 9.3 хувиар буурч, 2012 оныхоос 5.5 мянга буюу 4.7 хувиар нэмэгдэв. Сogтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж эрүүлжүүлэгдсэн 123.5 мянган хүний 63.9 нь буюу 51.8 хувь нь нийслэлд, 55.7 буюу 45.1 хувь нь аймгуудад, 3.8 буюу 3.1 хувь нь төмөр замд эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт нийт 449.2 сая төгрөгийг төлсөн байна.

Зураг 4.3.1. Эрүүлжүүлэгдсэн нийт хүн, мян.хүнээр, 2000, 2005-2013 он




Эрүүлжүүлэгдсэн хүний тоо 5.5 мянгаар нэмэгдэхэд Дорнод(7226), Дархан-Уул(5444), Орхон(5165), Сэлэнгэ (4015), Хэнтий(3678) аймгууд болон Улаанбаатар хотод (63903) эрүүлжүүлэгдсэн хүний тоо өндөр байгаа нь голлон нөлөөлжээ. Эдгээр аймаг, нийслэлд архи дан согтууралт өндөр байгаа нь тухайн нутаг дэвсгэрт, архины үйлдвэрлэл их байгаа нөгөөтэйгүүр ажилгүйдэл өндөр байгаатай холбоотой байх талтай.

Эрүүлжүүлэгдсэн нийт хүмүүсийн 6559 буюу 5.3 хувь нь эмэгтэйчүүд, 833 буюу 0.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 139 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс байна. Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг нийгмийн байдлаар нь авч үзвэл 98595 буюу 79.9 хувь нь ажилгүй иргэд, 10866 буюу 8.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1381 буюу 1.1 хувь нь ажилчин, малчин, 3729 буюу 3.0 хувь нь хувийн хэвшилд ажиллагчид, 1363 буюу 1.2 хувь нь оюутан, сурагчид, 1820 буюу 1.5 хувь нь төрийн албан хаагчид, 169 буюу 0.1 хувь нь тэнэмэл хүмүүс байна.

Захиргааны зөрчлийн улмаас 726716 иргэн, 52 албан тушаалтан, 1212 байгууллага, аж ахуйн нэгжид 4.8 тэрбум төгрөгийн торгуулийн арга хэмжээ авагджээ. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан 33.3 мянган зөрчил гарсан нь 2012 оныхоос 16.0 хувиар нэмэгдсэн байна.

2013 онд захиргааны зөрчлийн улмаас 16.5 мянган хүн баривчлагдсан нь 2006 оныхоос 2985 буюу 22.1 хувь, 2012 оныхоос 2.6 мянга буюу 18.8 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 4.3.2. Баривчлагдсан нийт хүн, 2000, 2005-2013 он



5. ОЛОН УЛСЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС

2010 онд цагдаагийн байгууллагад хүнийг санаатай алах гэмт хэрэг 230 бүртгэгдсэн бөгөөд 100000 хүнд ногдох түвшингээр урд хөршөөс бараг 9 дахин өндөр, хойд хөршөөс 17.2 хувиар доогуур байна.


Хүснэгт 5.1.1 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, сонгосон улсаар, 2010 он

	Хэргийн тоо	100000 хүн ноогдох
БНХАУ	13 410	1.0
Гонгхонг	35	0.5
Монгол	230	8.7
Пакистан	13 208	7.6
ОХУ	14 574	10.2

5.2. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл 2011 онд Монгол улсад 2010 оноос 19 буюу 13.2 хувь, Казахстанд 48 буюу 48.0 хувиар нэмэгдэж, харин Япон улсад 183 буюу 4.2 хувь, Гонгхонгд 92 буюу 11.4 хувь, Солонгосд 125 буюу 10.6 хувиар буурсан байна.

Зураг 5.2.1. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, сонгосон улсаар, 2007-2011 он




Хүснэгт 5.2.1. Хүчингийн хэрэг, сонгосон улсаар, 2005 - 2011 он

Азийн орнууд	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Казахстан	1,583	1,584	1,518	1,298	1,378	1,387	1,762
Киргизстан	298	271	300	303	303	314	331
Тажикстан	54	56	47	55	36	57	43
Гонконг	99	96	107	105	136	112	91
Япон	2,076	1,948	1,766	1,582	1,402	1,289	1,185
Монгол	320	314	355	354	332	342	367
100 000 хүнд ноогдох хүчингийн хэрэг							
Казахстан	10.4	10.3	9.8	8.3	8.7	8.7	10.9
Киргизстан	5.9	5.3	5.8	5.8	5.7	5.9	6.1
Тажикстан	0.8	0.9	0.7	0.8	0.5	0.8	0.6
Гонконг	1.5	1.4	1.6	1.5	1.9	1.6	1.3
Япон	1.6	1.5	1.4	1.3	1.1	1.0	0.9
Монгол	12.6	12.2	13.5	13.3	12.2	12.4	13.1
Эх үүсвэр: НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар							

100 000 хүнд ногдох хүчингийн хэрэг Монгол улсад 2011 онд 13.1 болсон нь 2005 оныхоос 0.5 пункт, 2006 оныхоос 0.9 пункт, 2009 оныхоос 0.9 пункт, 2010 оныхоос 0.7 пунктээр нэмэгдсэн бол 2007 оныхоос 0.4 пункт, 2008 оныхоос 0.2 пунктээр буурчээ. Сонгосон азийн орнуудтай харьцуулахад Монгол Улсад 100000 хүнд ноогдох хүчингийн хэрэг өндөр байна.

Зураг 5.2.2. 100 000 хүнд ногдох хүнийг санаатай алах гэмт хэрэг, сонгосон улсаар, 2004, 2007, 2010 оноор



6. ДҮГНЭЛТ

Улсын хэмжээнд 2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг (2095), хүний амь,бие, эрүүл мэндийн эсрэг(1001) зэрэг гэмт хэрэг нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 43.8 хувь, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 32.2 хувь,

тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8.5 хувийг эзэлж байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2012 оныхоос нэмэгдэхэд энэ төрлийн гэмт хэргийн 70.9 хувийг эзэлж буй бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 1618 буюу 25.8 хувиар, хувийн өмчийг хулгайлах хэрэг 1765 буюу 43.1 хувь, мал хулгайлах хэрэг 59 буюу 4.2 хувь, халаасны хулгайн хэрэг 177 буюу 71.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн тоо 8156 болж, 2012 оныхоос 1001 хэрэг буюу 14.0 хувиар өсөхөд энэ төрлийн гэмт хэргийн 92.7 хувийг эзэлж буй бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 7564 болж, 2012 оныхоос 1018 хэрэг буюу 15.6 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2148 болж, 2012 оныхоос 149 хэрэг буюу 7.5 хувиар нэмэгдэхэд, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах хэрэг 32 буюу 4.5 хувиар буурсан байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тоо буурахгүй байгаа нь тээврийн хэрэгслийн эрчимтэй өсөлт, замын чанар, жолоочийн ур чадвар, замын хөдөлгөөнд оролцогчдын соёл, үүрэг хариуцлагаас шалтгаалж байна. Иймд жолоочийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн орчин, жолооны сургалтын чанарыг сайжруулах, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох, замын түгжрэлийг багасгах, орон нутаг, гэр хорооллын замыг стандартын шаардлагад нийцрүүлэх шаардлагатай байна.

18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд улсын дундажаар 133 гэмт хэрэг ноогдож байгаа нь 2012 оныхоос дундажаар 16 хэрэг буюу 13.7 хувиар нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлт Говьсүмбэр (180), Төв(155), Дорнод(148), Дорноговь(138), Улаанбаатар (182) хотод улсын дундажаас дээгүүр байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 60.8 хувь нь Улаанбаатар хотод, 14.9 хувь нь төвийн бүсэд, 11.5 хувь нь хангайн бүсэд, 6.1 хувь нь баруун бүсэд, 5.9 хувь нь зүүн бүсэд гарсан байна. Улаанбаатар хотын дүүргүүдээс хамгийн их гэмт хэрэг гарсан нь Баянзүрх дүүрэг (3742) байна.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 2.2 хувиар, нийслэлд 4.8 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2013 онд 159.0 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын нийт хэмжээ 111.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос учирсан хохирлын хэмжээ 3 дахин, нөхөн төлүүлэлт 4.4 дахин нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 2013 онд 949 хүн нас барсны 424 буюу 44.7 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас, 204 буюу 21.5 хувь нь хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

Хохирогч өөрийн буруугаас болж хохирсон тохиолдол 365 гарсан нь 2012 оныхоос 238 буюу 39.5 хувиар буурчээ. Архидан согтуурсны улмаас 371 хүн хохирсон

нь өмнөх оныхоос 70 хүн буюу 15.9 хувиар буурчээ. 2013 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 319 хүн хохирсон нь өмнөх оныхоос 114 хүн буюу 26.3 хувиар буурав. Эдгээр хүмүүсийн 84.0 хувь нь бие махбодын хүчирхийлэлд өртжээ. Хохирогчдын 63.9 хувь нь 1 жил хүртэл, 14.7 хувь нь 1-3 жилийн туршид хүчирхийлэлд автаж байсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд автсан хүмүүсийн 63.0 хувь нь жилд 1-2 удаа, 2.2 хувь нь байнга хүчирхийлэлд автагджээ.

Гэмт хэргийн улмаас 2013 онд 25015 хүн хохирсны 949 хүн буюу 3.8 хувь нь нас барж, 9797 хүн буюу 39.2 хувь гэмтсэн байна. Тайлант онд хохирогч иргэдийн тоо 17.5 хувиар нэмэгдэхэд нас барсан иргэдийн тоо 5.3 хувь, гэмтсэн иргэдийн тоо 16.1 хувиар нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас 2013 онд нас барсан 949 хүний 44.7 хувь нь ТХХАБАЖ-ийн эсрэг, 16.9 хувь нь хүнийг санаатай алах, 26.7 хувь нь бусдыг амиа хорлоход хүргэх, 1.9 хувь нь бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн улмаас нас баржээ. Гэмт хэргийн улмаас 74 хүүхэд нас барж, 721 хүүхэд гэмтсэн байна. Авто ослын улмаас 36 хүүхэд нас барж, 197 гэмтсэн байна.

2013 онд 123.5 мянган хүн эрүүлжүүлэгдсэн нь 2000 оныхоос 24.6 мянга буюу 16.6 хувь, 2006 оныхоос 12.6 мянга буюу 9.3 хувиар буурч, 2012 оныхоос 5.5 мянга буюу 4.7 хувиар нэмэгдэв.

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2013 онд 1080 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсний 725 буюу 67.1 хувь нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 206 буюу 19.1 хувь нь цалин хөлсний маргаан, 36 буюу 3.3 хувь нь ажлаас буруу шилжүүлсэн хэрэг байна.

Шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргааны 17.1 хувь нь баруун бүсэд, 14.0 хувь нь хангайн бүсэд, 12.6 хувь нь төвийн бүсэд, 5.8 хувь нь зүүн бүсэд, 50.5 хувь нь Улаанбаатар хотод байна.

2013 онд 123.5 мянган хүн эрүүлжүүлэгдсэн нь 2000 оныхоос 24.6 мянга буюу 16.6 хувь, 2006 оныхоос 12.6 мянга буюу 9.3 хувиар буурч, 2012 оныхоос 5.5 мянга буюу 4.7 хувиар нэмэгдэв.

Эрүүлжүүлэгдсэн хүний тоо 5.5 мянгаар нэмэгдэхэд Дорнод(7226), Дархан-Уул(5444), Орхон(5165), Сэлэнгэ (4015), Хэнтий(3678) аймгууд болон Улаанбаатар хотод (63903) эрүүлжүүлэгдсэн хүний тоо өндөр байгаа нь голлон нөлөөлжээ.

Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг нийгмийн байдлаар нь авч үзвэл 98595 буюу 79.9 хувь нь ажилгүй иргэд, 10866 буюу 8.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1381 буюу 1.1 хувь нь ажилчин, малчин, 3729 буюу 3.0 хувь нь хувийн хэвшилд ажиллагчид, 1363 буюу 1.2 хувь нь оюутан, сурагчид, 1820 буюу 1.5 хувь нь төрийн албан хаагчид, 169 буюу 0.1 хувь нь тэнэмэл хүмүүс байна.

Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 79.9 хувь нь ажилгүй хүмүүс байгаагаас харахад ажилгүйдлээс үүдэж архидан согтууралт асар их нэмэгдэж байна. Иймээс бодлого боловсруулагчдын зүгээс ажлын байрыг нэмэгдүүлэх явдал зайлшгүй чухал байна.

7. Санал, зөвлөмж

- Гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн 44.7 хувь нь ТХХАБАЖ-ийн эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алдсан нь нийгэмд асар их хор хохирол учруулж байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тоо буурахгүй байгаа нь тээврийн хэрэгслийн эрчимтэй өсөлт, замын чанар, жолоочийн ур чадвар, замын хөдөлгөөнд оролцогчдын соёл, үүрэг хариуцлагаас шалтгаалж байна. Иймд жолоочийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн орчин, жолооны сургалтын чанарыг сайжруулах, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох, замын түгжрэлийг багасгах, орон нутаг, гэр хорооллын замыг стандартын шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.
- Гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнх нь гэр хорооллын болон орон сууцны хорооллын гудамжинд үйлдэгдэж байгаагаас харахад гудамж, талбайн гэрэлтүүлгийг сайжруулж, нэмэгдүүлэх нь зүйтэй байна.
- Гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүсийн талаас илүү хувь нь ажилгүй хүмүүс байгаагаас харахад шинээр ажлын байр бий болгоход анхаарах хэрэгтэй байна.
- Хүн худалдаалах гэмт хэрэг 2013 онд өмнөх оныхоос 1 буюу 11.1 хувиар өссөн байна. Охид, эмэгтэйчүүд, түүний дотор бага насны охидыг бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах, бага насны хүүхэд, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх, албадан хөдөлмөр хийлгэх, хүчирхийлэх явдалтай эрчимтэй тэмцэх, далд хэлбэрээр хүүхэд, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлж буй хэсэг бүлэг, хүний

наймаа эрхлэгчдийг илрүүлж таслан зогсоох чиглэлд анхаарлаа хандуулж ажиллах хэрэгтэй байна.

- Хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг өмнөх оныхоос 7.7 хувиар өссөн төдийгүй, хүн хулгайлах гэмт хэрэг 2 шинээр бүртгэгдснээс үзэхэд хүүхдээ хаяж, төөрүүлж буй эцэг эхэд ноогдуулах хариуцлагыг хуульчлах, хүний наймаа, садар самуунд уруу татах гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах болон бусдын эд хөрөнгийг хулгайлах, хувийн өмчийг хулгайлах, эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх, танхайрах гэмт хэргийн гаралт ч нэмэгдсээр байгаад анхаарч ажиллууштай байна.

..... о О о